

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVII (392)

2013

(47-55)

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ЗЭРГЭД БҮТЭХ
АРГЫН АСУУДАЛД
(Аман зохиолын жишээгээр)

Б. Мөнгөнцэцэг *

Монгол хэлний найруулгын тэгшлэх ёс буюу сондгойруулахгүйн ёсны сонгодог жишээний нэг болох ойролцоо зэргэд нь найруулах эрдмийн амин чухал зүйл юм. Олсон бодол, санасан санаагаа аль болохоор төгс төгөлдөр илэрхийлэхийн тулд олон ойролцоо санаанаас шилж сонгох хэрэгцээ хэн хүнд тохиолддог билээ. Үүнд ойролцоо зэргэдийн утга агуулга, түүний бүтэх арга чухал үүрэгтэй юм. Бид өмнө нь монгол хэлний ойролцоо зэргэдийг зөвхөн зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзсэн¹ тул уг өгүүлэлд аман зохиолын бусад төрөл зүйлд ойролцоо зэргэд хэрхэн илэрч байгааг тодруулсан болно.

Монгол хэлний ойролцоо зэргэд өгүүлбэрийг бүтээхэд ойролцоо үг чухал үүрэгтэй болох нь хэлний баримтаас харагдаж байна. Өнөөгийн хэлшинжлэлд “Хэлний түвшин бүрийн нэгж ойролцоо утгатай юм” хэмээн үзэх болсон бөгөөд Ю.Д.Апресян², Дж.Лайонз³, И.М.Кобозева⁴ зэрэг эрдэмтэд ойролцоо үгийг бүрэн ба бүрэн бус, тухайн

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Хэл шинжлэлийн тэнхим

¹) Б.Мөнгөнцэцэг. Монгол хэлний ойролцоо зэргэд, Уб., 2012

²) Ю.Д.Апресян. 1)ойролцоо утга бүрэн тохирох, 2) (“*достигать*”=“*хэмжээ*” (оновчтой буюу оновчтой бус), “*доходит до*”=“*тодорхой хэмжээ*” гэхэд эхнийх нь “бүхэл, ерөнхий” гэсэн утгатай бол сүүлчийн үг нь “хэсэг, тодорхой” гэсэн утгатай юм.) 3)ойролцоо утгын нэг нь нөгөөгөө (орос хэлний “*приниматься*”=“*үйл ажиллагаа*”, “*братья*”=“*үйл ажил*” гэсэн хоёр үгийн эхнийх нь хийсвэр, сүүлчийнх нь бодитой боловч “*приниматься|братья*” (орох, оролдох, хүлээн авах|хийж эхлэх) гэдэг ойролцоо үг нь “*братья|приниматься за работу|за учение|за чтение|за дело|за картину|за книгу|за письмо*” гэж бие биеэ солбицож болно, 4)ойролцоо үг нь утгаараа бүрэн тохирохгүй нь (квазисинонимия) болдог. Энэ нь төрөл зүйлийн утга бие биеэ нөхөн солбицдог. Жишээ нь, орос хэлний *объединение* (нэгдэл)-*союз* (холбоо), *остричь* (бүрмөсөн авах)-*постричь* (хэсгийг нь авах) гэж ангилаад (Ю.Д.Апресян, 1974, стр. 230-239), эдгээр дөрөв нь дотроо утгын ба үгийн, бүтээвэр-өгүүлбэрийн ойролцоо үгс гэж задран, 3x4=12 гэсэн ойролцоо үг бүтэх ажээ.

³) Дж.Лайонз. 1. бүрэн ба түгээмэл тохирох (Утга нь бүрэн тохирч, аль ч эхэд солиход утга өчүүхэн гаждаггүй) 2. бүрэн ба түгээмэл бус тохирох (Утгаар бүрэн тохировч, тухай тухайн эхэд сольж болдоггүй) 3. бүрэн бус ба түгээмэл тохирох (Утгын багтаамж өөр боловч аль ч эхэд сольж болно) 4. бүрэн бус ба түгээмэл бус тохирох (Үгийн утга, хэрэглээгээр үл тохирох ойролцоо үг) (Дж.Лайонз, 1999, 475)

⁴) И.М.Кобозева. ...бүрэн тохирох ойролцоо үг нь утгын ялгаа гарахгүй бөгөөд мэдэгдэхүүн ба мэдэхүүний хувьд ч, хэлэгдэхүүн ба хэлэхүүний хувьд ч ялгарахгүй (*бросать-кидать* (хаях-шидэх), *глядеть* (харах-үзэх), *везде* (газар сайгүй) –*всюду* (хааяагүй), *плебицит* (ардын санал хураах)-*референдум* (нийтийн санал хураах), *заснуть* (унтах)-*уснуть* (унтчих) зэрэг үгс байна. ... хэрэв ойролцоо үгс нь найруулга буюу үнэлэмжээрээ ялгарвал түүнийг мэдэхүүний ойролцоо үг (убегать-

эхэд сэлгэх ба эс сэлгэх гэж ангилсаар ирсэн нь хэлний бага нэгжийг их нэгж болгон хувиргахад ойролцоо үг бүтээвэр чухал үүрэгтэй байгаатай холбоотой юм. Бид хэлний баримтад түшиглэн монгол хэлний ойролцоо үгийг туйлын, оновчтой, оновчтой бус, хуурмаг⁵ гэж ангилсан⁶ ба ангилал тус бүрийг бодит ба хийсвэр утгын талаас ялган авч үзсэн билээ⁷. Уг ангиллыг жишээний хамт тодруулъя.

1. а. Хуучин үг (*ший*=*жүжиг*, *оточ*=*эмч*=*доктор*, *авла*=*агна*=*гөрөөл*), ормол үг (*шлян*=*бүрх*, *жааз*=*хүрээ*=*рам*), нутгийн аялгууны үг (*ирэг*=*хаяа*, *айвал*=*мануухай*, *одоох*=*нөхөр*, *балт*=*сүх*) нь өнөөгийн утга зохиолын хэлний үгтэй харьцахдаа нэг юмыг өөр өөрөөр нэрлэх тул **бодит утга бүхий туйлын ойролцоо үг** болно. (= гэдгээр утгаараа бүрэн тохирч буйг тэмдэглэв)

б. Нэр томъёоны үг (*эр бөднө*=*хулжуухай*, *үйлт нэр*=*цагт нэр*=*тэмдэг үйл*=*нэр тэмдэг*, *хэл шинжлэл*=*хэл судлал*, *морфем*=*бүтээвэр*) нь утга зохиолын хэлний үгтэй харьцахдаа нэг ухагдахууныг өөр өөрөөр нэрлэх тул **хийсвэр утга бүхий туйлын ойролцоо үг** болно. Эдгээр нь утгаараа бүрэн тохирно.

2. а. Нэг язгуураас дагаврын аргаар бүтсэн үгсийн дагавар нь өөр дагавартай тэнцүү утгатай байвал **бодит утга бүхий оновчтой ойролцоо үг** болно. Жишээ нь: *төлбөр*≠*төлөөс*, *шавар*≠*шавхай*≠*шаваас*, *буудлага*≠*буудалцаан*≠*буудалдаан*. Ийнхүү нэг язгуурт залгасан дагаврууд нь өөр хоорондоо бие даасан ойролцоо үг бүтээхийг ойролцоо ба төсөөт үгийн дундын буюу хоёрдмол шинжтэй гэж үзэж болно.

б. Ойролцоо үгийн нийлэх утганцар⁸ нь олон, ялгарах утганцар нь цөөн бол тэдгээрийн утга нь ойртох тул **хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг** болно. Жишээ нь: “*өтлөх*-*хөгширөх*-*өвгөрөх*-*насжих*-*зөнөх*” гэсэн ойролцоо үгсийн “*өтлөх*” гэдэг нь гол үг болох ба “*өтлөх*” гэхэд давын өмнө “*хөгширөх*” гэдэг үг санаанд буух төдийгүй нийлэх утганцар нь олон тул оновчтой ойролцоо үг болно. Харин бусад үгс нь утга холдсон ойролцоо үг болох ажээ. “*өвгөрөх*” гэвэл “*насжих*” хэмээх үг санаанд буух ба “*зөнөх*, *зөнөглөх*, *зөнтөх*” гэдэг нь “*өтлөх*-*хөгширөх*” “*өвгөрөх*-*насжих*” гэж хос хосоороо бяцхан ялгарсан ойролцоо үгсээс утгын хувьд хол болно. Эдгээр нь утгаараа бүрэн тохирохгүй. (≠ гэдгээр утгаараа бүрэн бус тохирч буйг тэмдэглэв)

3. а. Хүндэтгэлийн утгаараа ялгарч, бусад шинжээрээ адил бол **бодит утга бүхий оновчтой бус ойролцоо үг** болно. Жишээ нь: *нүд*≠*мэлмий*, *толгой*≠*тэргүүн*, *унтах*≠*нойрсох*.

б. Нэг үгийн гол ба салаа утга нь нөгөө үгийн гол ба салаа утгатай ойролцоо байж, дүрслэх ур маягаар бүтсэн бол **хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг** болохын зэрэгцээ хэлэнд хэвшсэн байдгаараа хийсвэр утга бүхий хуурмаг ойролцоо үгээс ялгарч байна. Жишээ нь: “*нөхөр*≠*сүүдэр*, *мандах*≠*бадрах*, *түргэн*≠*түүхий*” нь адилтгалаар бүтсэн бол “*хэл*≠*ам*, *түүх*≠*шастир*” нь орлолоор бүтсэн байна.

драпать-улепетивать) болох ба орос хэлний “*красивый-красота*, *доверять-доверие*” гэхэд бодит ба хийсвэр (утга ба хэлбэр), хэрэглээ (мэдэхүүний тал)-ний хувьд таарах авч, үгийн сан-хэлзүйн талаар ялгарч, хэлэхүүний (өгүүлбэрийн) ойролцоо үг болно (И.М.Кобозева, 2000, стр. 100)

⁵) туйлын ойролцоо үг- абсолютные синонимы, оновчтой ойролцоо үг- точные синонимы, оновчтой бус ойролцоо үг- неточные синонимы, хуурмаг ойролцоо үг- квазисинонимия (үүний “квази” нь латин хэлний “1. сэтгэлдээ бодсон, санаа дагах; 2. хуурмаг худал, шиг, мэт, бололтой” гэсэн утга бүхий “quasi” гэсэн үгнээс гаралтай аж.)

⁶) М.Базаррагчаа, Б.Мөнгөнцэцэг, 2011, 26

⁷) Б.Мөнгөнцэцэг. Дурдсан зохиол, Уб., 2012

⁸) утганцар- семантический множитель (сема)

4. а. Тухайн эхэд төрөл (род) зүйл (вид)-ийн харьцааг илтгэж, утгын ялгаа нь бүдгэрч саармагшсан бол **бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг** болно. Жишээ нь: “зангидах, бэхлэх, тогтоох” гэсэн утгатай “уях” гэсэн үг нь “алив юмыг хязгаарлах, тогтоох” гэсэн утгатай “сойх” хэмээх үгтэй хоршиж ойролцоо үг бүтээнэ. Гэтэл энэ үг нь “морь уралдуулахаар засах” гэсэн утгаар ижилсэж буй нь уул хоёр үгийн утга саармагшиж хуурмаг ойролцоо үгийг бий болгожээ.

б. Тухайн үгс нь утгын холбогдолгүй боловч эхэд ойролцоо утга илтгэх, дүрслэх ур маягаар бүтсэн боловч эс хэвшсэн бол **хийсвэр утга бүхий хуурмаг ойролцоо үг** болно. Жишээ нь: “осгох≠хөлдөх≠хөрөх” гэсэн ойролцоо үүр үгсээс ялгарсан “царцах” гэсэн үг нь “шингэн зүйлийн бага зэрэг хөлдөх, зайрмагтах” гэсэн утганцраар тухайн эхдээ зохицон, улмаар юм үзэгдлийн шинжийг заасан үгээр адилтган тодруулж гаргасан байна.

Өгүүлбэр ба цогцолборын санаа нь хэлзүйн үндэс, нөхцөл хоёр буюу үгс (гишүүд)-ийн утгад тулгуурлах бөгөөд аман зохиол (зүйр цэцэн үгээс бусад төрөл) дахь ойролцоо зэргэд яаж бүтсэнийг задалбал дараах байдлаар ангилж болмоор байна. Үүнд:

А. Ойролцоо үг, зүйлийн үг⁹ээс бүтсэн ойролцоо зэргэд

1) Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн:

Аавдаа ачтай

Ээждээ тустай (МАЗ-ын дээж бичиг, 1967, 125 т. Бэлгэ дэмбэрлийн үг)

гэхэд “ач тус” (тус нэмэр), “аав ээж” (эцэг эх) хэмээх ойролцоо хоршоо үг нь хос мөрөнд зэрэгцэн, зэргэд бүтээжээ. а. ач - гүнээ хүндэтгэвэл зохих эрхэм тус, сайн буян; б. тус - ая, дэм, нэмэр, ашиг, тус (Баярсайхан, 2009, 47, 668) нь үндсэн утгаараа таарч, уул эхийн доторх өгүүлбэрт өөр хооронд нь солиход утга өчүүхэн ч үл гажихаас гадна “ач” гэхэд давын өмнө “тус” гэдэг үг санаанд буух тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно. Түүнчлэн “аав (төрсөн эцэг)- ээж (тээж төрүүлсэн эмэгтэй, эх)” гэсэн хүний зүйлийг нэрлэсэн үгээс бүтэхийн сацуу сүүл холбосон байна.

Түшвэл ах мэт

Тулбал дүү мэт (МАЗ-ын дээж бичиг, 1967, 276 т. “Монгол-Зөвлөлтийн их нөхөрлөл”

магтаалаас)

“түших тулах” (а.унах, хазайх юманд тулгуур хийх; *б.шилж.* ажил хэрэгт нөмөр нөөлөг болгох, бусдын дэм тусыг авах); “ах дүү” (а.нэг эхээс төрсөн хүүхдүүд, б.төрөл садан хүмүүс, в.насаар зөрүү хүмүүс) хэмээх ойролцоо хоршоо үг нь хос мөрөнд зэрэгцэн, зэргэд бүтээжээ. Толь бичигт а. түших - 1.юманд тулж налах, хажуулах; 2.хазайсан

⁹⁾ Хэлний мэдэгдэхүүн (ономазиология) нь юмыг ангилан үздэг. Нэрлэгдэхүүнийг

1. Хүний зүйлс (*Эрдэнэ Очир, би, чи, тэр, гар, хөл, өвөлжөө, алба, нүд, чих, хамар, ам, арьс, яс, хэн, юу, яа*);
2. Адгуусны зүйлс (*чоно, баавгай, ялаа, өт, сармагчин, адуу, хонь, нохой, юу, яа*);
3. Ургамлын зүйлс (*мод, нарс, цэцэг, навч, үндэс, юу, яа*);
4. Хүний бүтээсэн зүйлс (*авдар, хувин, гэр, тооно, чөдөр, хашаа, уяа, сур, хазаар, тэрэг*);
5. Адгуусны бүтээсэн зүйлс (*нүх, хөөө, үүр, ичээ, төвөргөөн, мөөрөх*);
6. Гараг ертөнцийн зүйлс (*далай, од, тэнгэр, шороо, газар, нутаг, нар сар, булаг шанд, уул, агаар*);
7. Сэтгэхүйн зүйлс (*ухаан, бодол, санаа, атаа*);
8. Мэдрэхүйн зүйлс (*уур хилэн, баяр цэнгэл, өвчин зовлон, хүч чадал, тамир, хайр дурлал*);
9. Зөн билгийн зүйлс (*зөн, билиг, зүүд*);
10. Хий үзэгдлийн зүйлс (*буг чөтгөр, бурхан, сүнс сүг*) (Базарагчаа, 1993, 14-17) гэж ангилсан ба дээрхээс гадна юмсын “чанар, тоо, орон, цаг” гэсэн дөрвөн хийсвэр шинжийн зүйлийг нэмж болно.

буюу тогтоц муутай зүйлийг тулж тогтоох, дэмнэх, тэтгэх; 3.шилж. аж амьдрал, ажил төрөлд бусдыг итгэж нөхөрлөх; 4.шилж. өгөх, барихын хүндэтгэл; 5.хуучир. тушаалд томилох, өргөмжлөх; б. тулах - 1.тулгуур болох, түших, баганадах, 2.тулгуур хийх, 3.юмны эцэс, хаяа, ирмэгт хүрэх, 4.нэлээд ойртох, шахах, 5.шилж. биеэр учрах, 6.шилж. байлдах, дайтах, 7.шилж. хэрэлдэх, тэмцэлдэх, 8.шилж. хоёр юмыг хооронд нь шууд солилцох (Баярсайхан, 2009, 682, 663) гэж тайлбарласнаас үзвэл, энэ хоёр үгийн олонх утганцар таарч, цөөнх утганцар нь ялгарсан тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно. Түүнчлэн “ах (эцэг, эхээс төрсөн хүүхдийн эрэгтэй бөгөөд насаар илүү нь)-дүү (насаар бага)” гэсэн хүний зүйлийг нэрлэсэн үгээс бүтэхийн зэрэгцээ толгой, сүүл холбосон байна.

2) **Оновчтой бус ойролцоо үг нь хийсвэр шинж бүхий (чанар, тоо, орон, цаг) зүйлийн үгтэй холбогдон бүтсэн:**

Архи нэртэй боловчиг

Аригуун чанартай идээ

Сархад нэртэй боловчиг

Сайхан чанартай идээ (МАЗ-ын дээж бичиг, 1967, 120 т. Архи, айргийн ерөөл)

Найруулгын утгаар ялгарах “архи (цагаа, тариа будаа болон жимсний шүүсийг нэрж гаргасан согтууруулах ундаа) – сархад (архины хүндэтгэл нэр)” гэсэн бодит утга бүхий оновчтой бус ойролцоо үг нь “аригуун (ариун)- (1.алив зүйлийн хир буртаггүй, цэвэр тунгалаг, 2.худал хуурмаггүй, цэгц шударга, үнэнч, 3.эрхэм дээд, нандин, нарийн) – сайхан (1.хүн, амьтан, юмс үзэгдлийн үзэмж төгөлдөр, 2.зохистой, тааламжтай, 3.цагаан цайлган, шударга, 4.ээлдэг дотно, 5.амгалан тайван) гэсэн хийсвэр шинж бүхий чанарын зүйлийг нэрлэсэн үгтэй холбогдон бүтсэн байна.

Мянган үхрийн манлай бол

Түмэн үхрийн түрүүнд яв (МАЗ-ын дээж бичиг, 1967, 103 т. Дом шившлэгийн үг: Үхэр

ханиахад)

гэхэд найруулгын утгаар ялгарах “манлай бол- (манлайлах) (1.тэргүүлэх, 2.түрүүлэх) – түрүүнд яв- (түрүүлэх)” гэсэн бодит утга бүхий оновчтой бус ойролцоо үг нь бодит тоон утгаараа адилгүй боловч “олон” гэсэн утга илтгэх “мянган – түмэн” гэсэн хийсвэр шинж бүхий тооны зүйлийг нэрлэсэн үгтэй холбогдон бүтсэн байна.

3) **Бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн:**

Бурханд чинь мөргөх юм бол

Булчингаа суга татуулна би

Шашинд чинь сүсэглэх юм бол

Шандсаа ховх татуулна би (МАЗ-ын дээж бичиг, 1967, 109 т. Буурал голын бөөгийн

тамлага)

“бурхан (1.буддын ёсны гэм бүхнийг тэвчиж, эрдэм бүхэнд төгс, хамгийг эрхшээсэн хүн, 2.шашны ёсны илтгэл болсон олон сахиус шүтээн, бурхны дүрс бүхий хөрөг) – шашин (ном, сургаал, цааз зэргийн утгатай бөгөөд байгаль нийгмийн ер бусын хүчний тусгал болж, түүнээс өөр өөрсдийн танин мэдэхүйн хэлбэрээр үүдсэн үзэл, номлол, шүтлэг бишрэлийн нэгдмэл ойлголт, үзэл суртлын нэгэн зүйл давхарга, олон зүйл ялгавартай); мөргөх (мөргөл үйлдэх) – сүсэглэх (гүнээ итгэн үнэмших, бишрэх, хүсэн дуудах) нь тухайн хам сэдэвтээ ойролцоо утга илтгэн, “төрөл-зүйл, зүйл-зүйл”-ийн утгаар ялгарч, бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг болохын зэрэгцээ “булчин (1.биезүй.хүн, амьтны агших сунах чадалтай хөдөлгөөнт эрхтэн, 2.хүн, амьтны гар хөлний

булцгар махны тусгай нэр) – шандас (1.шөрмөс, 2.булчингийн хүч)” нь хүний зүйл болно.

Гэр нэвт гэгээгээр

Туурга нэвт туяагаар (МАЗ-ын дээж бичиг, 1967, 119 т. Хадгийн ерөөл)

“гэгээ (шууд бус туссан гэрэл, юм харагдахуйц гэрэлтэй болсон нь) – туяа (ямар нэг гэрэл бүхий юмнаас дам болон ойж гарах тод зурвас гэрэл) нь тухайн хам сэдэвтээ ойролцоо утга илтгэн, “зүйл-зүйл”-ийн утгаар ялгарч, бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг болохын зэрэгцээ “зэр (монгол угсаатны уламжлалт, оршин суух үндэстний эсгий сууц) – туурга (гэр, асар, цацрын хажуу талаар нөмөргөн бүтээх эсгий, бөс)” нь хүний бүтээсэн зүйл болно.

Б. Дан ойролцоо үгээс бүтсэн ойролцоо зэргэд

1) Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үгтэй холбогдон бүтсэн:

Гэмтэйгээс гэтэлгэсэн

Гайтайгаас гаргасан (МАЗ-ын дээж бичиг, 1967, 107 т. Хуулар бөөгийн дуудлага)

Толь бичигт “зарах” хэмээх үгийн

1. дотор, далд байсан юм гадагш шилжин байрлах, ил болох

2. төрөх

3. зайлах, салж ангижрах, хагацах гэсэн салаа утгын 3 дахь нь “ямар нэгэн юм, учрал тохиол, аюул тотгорыг туулан гарах” гэсэн утга бүхий “зэглэх” хэмээх үгтэй;

“гай” хэмээх үгийн

1. зовлон, балаг

2. уршиг, муу нөлөө

3. *шин.* зовлонгийн гэм гэсэн салаа утгын 2 дахь нь “ёс зүй, хууль зүйгээс ангид хийсэн үйл явдал, түүний уршиг нөлөө” гэсэн утга бүхий “зэм” хэмээх үгтэй тус тус таарч буй тул хийсвэр утга бүхий ойролцоо үг болох бөгөөд эдгээр ойролцоо үгс нь утга, хэлбэр¹⁰ ийн хувьд эн зэрэгцэн зэргэд бүтээжээ.

Сүр их сүртэнгүүд

Бар их бараатангууд (МАЗ-ын дээж бичиг, 1967, 106 т. Хуулар бөөгийн дуудлага)

гэхэд “бараа сүр” (а.гадаад байдал, б.юмны алсаас үзэгдэх байдал) хэмээх ойролцоо хоршоо үг нь хос мөрөнд зэрэгцэн, зэргэд бүтээжээ. а. “сүр”- хүн, амьтан болон юмны гайхалтай, бахдалтай, аймаар, болгоомжилмоор дүр байдал; б. “бараа”- 1.юмны алсад үзэгдэх овор байдал; алсаас үзэгдэх дүрс, хэмжээ, 2.*шилж.* хань болох хүн, хамт байх хүн, 3.*шилж.* шадар хань (Баярсайхан, 2009, 581, 67) нь үндсэн утгаараа таарч, уул эхийн доторх өгүүлбэрт өөр хооронд нь солиход утга өчүүхэн ч үл гажих тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно.

2) Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь хуурмаг ойролцоо үгтэй холбогдон бүтсэн:

Санасан нь саадгүй

Бодсон нь боодосгүй (МАЗ-ын дээж бичиг, 1967, 106 т. Хуулар бөөгийн дуудлага)

гэхэд “санах бодох” (бодол санаа төрөх) хэмээх ойролцоо хоршоо үг нь хос мөрөнд зэрэгцэн, зэргэд бүтээжээ. а. санах -1.сэтгэх, бодох, 2.өнгөрсөн хэрэг явдал бодолд

¹⁰ “хэлбэр” гэдгийг “хэлзүйн ижил төстэй бүтэц” гэсэн утгаар хэрэглэв.

орох, нэхэн дурсах, 3.ирээдүйн явдлыг төлөвлөн бодох, хүсэл өвөрлөх, 4.хүсч мөрөөдөх; – *бодох* -1.сэтгэх, нягтлах, эргэцүүлэн санах, хянах, 2.тооцох, тооны бодлогын хариуг олж гаргах, 3.санан дурсах, эрхэмлэх, 4.таамаглах, нарийвчлах, 5.*шилж.* муу санах, 6.харьцуулж адилтгах (Баярсайхан, 2009) гэж тайлбарласнаас үзвэл, энэ хоёр үгийн олонх утганцар таарч, цөөнх утганцар нь ялгарсан тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно. Харин “1.ямар нэгэн зүйлийг гүйцэтгэхэд тохиолдох бэрхшээл, тогтор, 2.явах, зорчих замыг хааж хорих хориг хаалт” гэсэн утгатай “*саад*”-ыг “ачаа бараа зэрэг юмыг бооход хэрэглэх уяа, оосор, ороолт, ваадан” гэсэн утгатай “*боодос*”-той утгаар нь харьцуулбал адилтгалаар бүтэхийн сацуу хэлэнд эс хэвшсэн тул хийсвэр утга бүхий хуурмаг ойролцоо үг болно.

Төрд нэртэй

Түмэнд цуутай

Улсад алдартай

Олонд цолтой (МАЗ-ын дээж бичиг, 1967, 125 т. Бэлгэ дэмбэрлийн үг)

1. *нэр* -1. юм үзэгдлийг үгээр ялган тэмдэглэсэн нь
 2. хүн, амьтанд оноож өгсөн дуудах үг
 3. алдар, дуурсгал: нэр цол_{хори.} (а.алдар, хэргэм зэрэг, б.*шилж.* хоч);
нэр цуу_{хори.} (олон даяар магтагдаж дуурссан алдар)
 4. үйл явдлын дуурсгал
2. *алдар* – 1_{хүндэт.} нэр
 2. гавьяа зүтгэл, авьяас чадвар, амжилтаараа олон түмэнд түгж мандсан нэр: алдар нэр/нэр алдар_{хори.} (а.тухайн хүнийг төрөхөд өгсөн дуудах үг, б.*шилж.* олон түмэнд үнэлэгдэх байдал);
алдар цол_{хори.} (нэр цол);
алдар цуу_{хори.} (олонд түгсэн нэр хүнд)
3. *цол* – 1. хүний албан тушаал, мэргэжлийн зэрэг, цэргийн албаны зэрэг дэвийг ялгахын тул албан ёсоор олгосон хэргэм зэрэг, өргөмжлөл, дэс:
алдар цол_{хори.} (хүний алдар гуншин, гавьяа шагнал)
 2. гавьяа байгуулагсдад төр засгаас мялаах алдар
3_{шилж.} хоч нэр: нэр цол_{хори.}
4. *цуу* – нэр алдар: алдар цуу_{хори.}, нэр цуу_{хори.}
гэсэн зэргэд бүтээж буй ойролцоо үүр үгсийн “нэр” нь гол үг (доминант) болох ба “нэр” гэхэд давын өмнө “алдар” гэдэг үг санаанд буух тул хамгийн оновчтой ойролцоо үг болох төдийгүй хоршоо үг бүтээх нь ч элбэг байна. Толь бичигт “төр” хэмээх үгийн “1.нийгэмд удирдлага, нийтлэг засаглалыг хэрэгжүүлдэг улс төрийн байгуулал, 2. улс: улс төр_{хори.} (а.улсын засаг, б.улсын гадаад, дотоод төрийн бодлого” гэсэн салаа утгын 2 дахь нь “нэгэн орны ноёрхох ангийн эрхэм ашгийг хамгаалсан, зохион байгуулалт бүхий орон, тусгаар тогтносон төрийн эрхт ёс бүхий гүрэн” гэсэн утга бүхий “улс” хэмээх үгтэй тус тус таарч буй тул хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг болно. Харин “түмэн (*шилж.* ард олон, зон) – олон (*шилж.* нийтээр, бүгд бултаар)” нь дүрслэх ур маягаар бүтэн, утгаараа бүрэн бус тохирч, хэлэнд хэвшсэн тул хийсвэр утга бүхий хуурмаг ойролцоо үг болох бөгөөд эдгээр ойролцоо үгс нь утга, хэлбэрийн хувьд эн зэрэгцэн зэргэд бүтээжээ.

Дээрх ангилал (аман зохиолын бусад төрөл зүйл дэх)-ыг зүйр цэцэн үгийн жишээн дээрх ангилалтай харьцуулья.

I. Ойролцоо үг, зүйлийн үгээс бүтсэн нь:

Зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзэхэд, нийт 483 ойролцоо зэргэдээс ойролцоо үг, зүйлийн үгээс бүтсэн нь 92 байгаа бол аман зохиолын бусад төрөл зүйл дэх 96 ойролцоо зэргэдээс уг ангилалд хамаарагдах нь 75 байна. Үүнийг ангилал тус бүрээр тодруулъя.

<i>Зүйр цэцэн үг</i>	<i>Тоо</i>	<i>Хувь</i>	<i>Аман зохиолын бусад төрөл</i>	<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1.Хийсвэр утга бүхий оновчтой, оновчтой бус ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн	46	50%	1.Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн	18	24%
2. Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь хийсвэр шинж бүхий (чанар, тоо, орон, цаг) зүйлийн үгтэй холбогдон бүтсэн	23	25%	2.Оновчтой бус ойролцоо үг нь хийсвэр шинж бүхий (чанар, тоо, орон, цаг) зүйлийн үгтэй холбогдон бүтсэн	9	12%
3.Бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн	23	25%	3.Бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн	48	64%
Бүгд	92	100%	Бүгд	75	100%

Монгол хэлний ойролцоо зэргэдийг зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзэхэд ихэвчлэн хийсвэр утга бүхий оновчтой, оновчтой бус ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтсэн байгаа бол аман зохиолын бусад төрөл зүйлд ихэвчлэн бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг нь зүйлийн үгтэй холбогдон бүтэж, улмаар уг хэлэх гэсэн зүйлийнхээ санааг лавшруулан давтсан байхын зэрэгцээ толгой холбон сүүл дарж, үгийн тоог тэнцүүлсэн байна.

II. Дан ойролцоо үгээс бүтсэн нь:

Зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзэхэд, нийт 483 ойролцоо зэргэдээс дан ойролцоо үгээс бүтсэн нь 54 байгаа бол аман зохиолын бусад төрөл зүйл дэх 96 ойролцоо зэргэдээс уг ангилалд хамаарагдах нь 21 байна. Үүнд:

<i>Зүйр цэцэн үг</i>	<i>Тоо</i>	<i>Хувь</i>	<i>Аман зохиолын бусад төрөл</i>	<i>Тоо</i>	<i>Хувь</i>
1. Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үгтэй холбогдон бүтсэн	15	28%	1.Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үгтэй холбогдон бүтсэн	9	43%
2.Оновчтой, оновчтой бус ойролцоо үг нь хуурмаг ойролцоо үгтэй холбогдон бүтсэн	29	54%	2.Хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг нь хуурмаг ойролцоо үгтэй холбогдон бүтсэн	12	57%
3.Хуурмаг ойролцоо үг нь хуурмаг ойролцоо үгтэй холбогдон бүтсэн	10	18%			
Бүгд	54	100%	Бүгд	21	100%

Монгол хэлний ойролцоо зэргэдийг зүйр цэцэн үг болоод аман зохиолын бусад төрөл зүйлийн жишээн дээр авч үзэхэд ихэвчлэн оновчтой ойролцоо үг нь хуурмаг

ойролцоо үгтэй холбогдон бүтэхийн зэрэгцээ толгой холбон сүүл дарж, хэлзүйн ижил төстэй бүтцэд байна. Энэ нь өөр өөр үйл явдлыг ойролцоо байдлаар ухаж ойлгосонтой холбоотой гэж үзэж болно.

Түүнчлэн зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзэхэд, нийт 483 ойролцоо зэргэдээс дүрслэх ур маяг (адилтгал, зүйрлэл, ёгтлол, егөөдөл, орлол, төлөөлөл)-аар үүссэн нь 337, үүнээс 201 буюу 60% нь адилтгалаар бүтэж байсан бол аман зохиолын бусад төрөл дэх ойролцоо зэргэд нь дүрслэх ур маягаар бүтээгүй, зөвхөн ойролцоо үг болоод зүйлийн үгээс бүтэж байна.

Өгүүлбэрийн зэргэд хэрхэн бүтэх ёсыг утга хэлбэр болон гаргалгын талаас нарийвчлан үзэх нь тэгшлэх найруулга буюу “экспрессивный синтаксис” хэмээх зүйлд шууд хамаарах болно. Монгол хэлний ойролцоо зэргэд нь аман зохиолын төрөл зүйлүүдээс ихэвчлэн зүйр цэцэн үгийн жишээн дээр илрэхийн зэрэгцээ зан үйлийн холбогдолтой аман зохиол, бөө мөргөлийн яруу найраг, ерөөл, магтаал, туулийн төрөл зүйлд цөөнгүй байна. Тодруулбал:

- Зан үйлийн холбогдолтой аман зохиол:
 - Хурим найрын зан үйл: Молорын үг, Ам турших
 - Дом шившлэгийн үг: Үхэр ханиахад
- Бөө мөргөлийн яруу найраг:
 - Хар зүгийн дуудлага: Хуулар бөөгийн дуудлага, Буурал голын бөөгийн тамлага
- Ерөөл:
 - Архи, айргийн ерөөл, Хадгийн ерөөл, Даахины ерөөл, Бэлгэ дэмбэрлийн үг
- Магтаал:
 - Монгол-Зөвлөлтийн их нөхөрлөл, Таван хошуу малын магтаал
- Тууль:
 - Алтай хайлах

Монгол хэлний ойролцоо санаа бүхий зэргэдийг тусгайлан зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзэхэд ихэвчлэн дүрслэх ур маягаар бүтэж байсан бол аман зохиолын бусад төрөл зүйлд ихэвчлэн ойролцоо үг болоод зүйлийн үгээс бүтэж, улмаар уг хэлэх гэсэн зүйлийнхээ санааг лавшруулан давтсан болох нь хэлний баримтаас ажиглагдлаа. Ийнхүү монгол хэлний ойролцоо зэргэдийг аман зохиолын жишээн дээр бүтэх аргын хувьд ялгаж, илрэх хэлбэр, онцлог, зүй тогтлыг гаргах нь монголчуудын найруулах эрдэм төдийгүй, ертөнцийг танин мэдэх арга хэрэглүүр бүтээсний үнэ цэнийг нээж гаргахад тус дөхөм болно.

НОМ ЗҮЙ

Ю.Д.Апресян. Лексическая семантика. Синонимические средства языка. М., 1974

М.Базаррагчаа. Орчин цагийн монгол хэлний энгийн өгүүлбэр. Уб., 1993

М.Базаррагчаа, Б.Мөнгөнцэцэг. Монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүн, мэдэхүүн ба хэлэгдэхүүн, хэлэхүүний талаас үзэх нь. “Монгол судлал”, МУИС., МХСС., XXXIII боть, Уб., 2011

- Б.Баярсайхан. Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг. Уб., 2009
Эрхэлсэн Б.Баярсайхан, хянан тохиолдуулсан А.Янжиндолгор
И.М.Кобозева. Лингвистическая семантика. М., 2000
Д.Лайонз. Введение в теоритическую лингвистику. Благовещенок., 1999
М.Гаадамба, Д.Цэрэнсодном. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Уб., 1967
Б.Мөнгөнцэцэг. Монгол хэлний ойролцоо зэргэд. Уб., 2012

ABSTRACT

The accurate study of the formation of sentence parallelism according to it's meaning, form, and inference is related to the "express stylistic" or direct stylistic. Parallelism in Mongolian language revealed among proverbs in folklore group, sometimes it can be appeared in folklore based on custom and tradition, shamanism verses, praise, and hymn and epics.

While I was studying the Parallelism which has similar meaning particularly based on the examples of proverbs, they was formed with the description way but in folklore they formed with the synonyms and different noun types gradually it can be seen that they were repeated their meaning in deep according to the language fact. To classify Parallelism in Mongolian language based on the folklore examples, also to determine it's Formation method, feature, principle is can be the talent of stylistic but also it would mean great effect to reveal the value of creating the tool to recognize the world.